# ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

## 2016-2021

*ОНСБТ-ийн ахлах эдийн засагч*
*Н.Батжин*

# ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

**60%** нь инфляци хадгаламжинд нь хэрхэн нөлөөлөх талаар ойлголтгүй



**10** хүний **6** нь инфляц хадгаламжинд хэрхэн нөлөөлөх талаар ойлголтгүй

Судалгаанд оролцогчдийн **70%** нь зөвхөн 3 төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын төрлийг мэддэг



Хүн амын **57%** нь ирээдүйгээс илүү одоо байгаа нөхцөл байдалдаа илүү анхаарлаа хандуулдаг






**30%** орчим нь хүүгийн талаар мэдлэггүй

**3** хүний **1** нь хүүгийн талаар мэдлэггүй

# Дэлхийн чиг хандлага - Санхүүгийн боловсрол

Санхүү, эдийн засгийн тогтвортой байдлаа хангахын тулд бодлого боловсруулагчдын түвшинд санхүүгийн боловсролд анхаарч илүү эрчимтэй ажиллаж эхэлсэн бөгөөд олон улсын бодлогын баримт бичгүүдэд тусгагдах болсон.







2013 онд хөгжсөн болон хөгжиж буй эдийн засагтай нийт **45** оронд иргэдийн санхүү, эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх бодлогын хэмжээнд анхаарч хөтөлбөр болгон хэрэгжүүлж байсан бол **2021** оны байдлаар дэлхийн **129** орон болон өргөжин тэлсээр байна.

# Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр




"**Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр**"-ийг Монголбанк, Сангийн яам, БСШУЯ, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн хамтарсан тушаалаар батлагдсан.

# Ач холбогдол

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, **хуримтлал болон хөрөнгө оруулалтыг** нэмэгдүүлэх, санхүүгийн эрсдэлээс өөрийгөө хамгаалах, санхүүгийн хүртээмж нэмэгдэх, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжинэ.

- **Санхүүгийн тогтвортой байдлыг хангах**
- **Шударга өрсөлдөөн**
- **Санхүүгийн хүртээмж**
- **Харилцагчдийн санхүүгийн сахилга бат**
- **Санхүүгийн харилцагчдын эрх ашгийг хамгаалах**

# Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл

**Олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр**

## Стратегийн Чиглэлүүд



Сургуулийн насныханд



Залуу үед



Хөдөө орон нутгийн иргэд

Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр

# Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн мэдлэг олгох

Санхүүгийн боловсрол олгох **“Бизнес судлал”** хичээлийг ЕБС-ийн **10,11,12** дугаар ангид сонгон судлахаар тусгагдсан / БСШУЯ-ны 2016 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/275 тоот тушаал/

БШУЯ-ны харьяа Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэнтэй хамтран нийслэл, 21 аймагт “Бизнес судлал” хичээлийг улсын хэмжээнд заах нийт **1870** багш нарт сургалтыг зохион байгуулав.











# Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн мэдлэг олгох

- Монголбанк бусад талуудтай хамтран жил бүр **Дэлхийн мөнгөний долоо хоног** буюу /Money week/-ийг жил бүр **3-р сард**, **Дэлхийн хуримтлалын өдрийг 10-р сард** тэмдэглэж бага, дунд, ахлах сургуулийн сурагчид болон багш нарын дунд уралдаан, сургалт, аян, арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.



# Залуу үед санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд

- Залуу үед санхүүгийн мэдлэг олгох **“Хувь хүний санхүү”** сэдэвт (3 кредит) хичээлийг хичээлийг **11** их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна.

ХНХЯ-тай хамтран МСҮТ /Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв/-ийн сургалтын хөтөлбөрт “Хувь хүний санхүү” хичээлийг 2017 оны 9 сараас эхлэн нийт **90** МСҮТ-ийн багшийг бэлтгэсэн бөгөөд **54000 гаруй** сурагч үзээд байна. (ХНХ сайдын А/138 тушаалаар)






# Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд

Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн мэдлэг олгох **13** төрлийн гарын авлага боловсруулан түгээж байна.




Монголбанкны орон нутгийн салбаруудаараа дамжуулан орон нутгийн иргэд, банк санхүүгийн салбарын ажилтнууд болон зорилтот бүлгүүдэд санхүүгийн боловсролыг түгээн ажиллаж байна.




Монголбанк, БШУЯ-ны харъяа Насан туршийн боловсролын үндэсний төв, СЗХ, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран **729** санхүүгийн сургагч багш нарыг өнгөрсөн хугацаанд бэлтгэж, иргэдэд мэдлэг, мэдээлэл өгөх чиглэлээр ажиллав.



# Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох

- Санхүүгийн мэдлэг олгох [www.sankhuugiinbolovsrol.mn](http://www.sankhuugiinbolovsrol.mn) албан ёсны цахим хуудсыг олон улсын туршлага, Дэлхийн банкны техникийн туслалцааны хүрээнд боловсруулан олон нийтэд түгээн ажиллаж байна.
- Иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ удирдах **“Төсөвчин” аппликейшнийг** бүтээв.
- Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх **“Подкаст”** дугааруудыг цахим орчноор бэлтгэн хүргэж байна.






PODCAST



Төсөвчин апп

YouTube

# Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох

- Санхүүгийн боловсрол олгох **1-2 минутын онлайн шторкуудыг** “Хуримтал, “Санхүүгийн боловсрол гэж юу вэ?”, “Санхүүгийн боловсролын суурь ойлголт”, “Төв банк юу хийдэг вэ?”, “Инфляци”, “Бодлогын хүү”, “Валютын ханш” зэрэг сэдвүүдээр тус тус бүтээж, олон нийтэд түгээж байна.
- Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох зорилгоор Монголын Үндэсний Радиотой хамтран ажиллаж **70** гаруй дугаар бэлтгэн хүргээд байна.






# Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

- Дэлхийн банкны техникийн туслалцааны хүрээнд Бизнес судлал хичээлийн 10,11,12 дүгээр ангийн сурах бичгийг боловсруулах, цахим хуудсыг хэрэгжүүлэх, сургагч багш нарыг бэлтгэх ажил дээр хамтран ажиллав. 2018 оны хувьд Дэлхийн банкны техникийн туслалцаа орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол түгээх чиглэлээр үргэлжилж байна.

---

- Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээний байнгын гишүүнээр 2017 онд элсэж, OECD-ийн гишүүн орнуудын санхүүгийн боловсролын талаарх олон улсын сайн туршлагууд болон зөвлөмж, уулзалт арга хэмжээнүүдэд тогтмол оролцон ажиллаж байна.
- ХБНГУ-ын Хадгаламжийн банкны олон улсын хамтын ажиллагааны сантай хамтран “Монгол улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалт” болон санхүүгийн боловсрол олгох, “Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”- ийг хэрэгжүүлж байна.
- Монголбанк, ЕСБХБ-аас хамтран хэрэгжүүлж байгаа “Бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох” хөтөлбөрийг боловсруулж, 32 сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдлаа.

# Гадаад харилцаа, хамтын ажиллагаа













- ✓ БШУЯ
- ✓ Сангийн яам
- ✓ СЗХ
- ✓ ХНХ-ийн яам
- ✓ НТБҮТ
- ✓ БМДИ
- ✓ ЦЕГ
- ✓ Боловсролын хүрээлэн
- ✓ ГХЗГ
- ✓ МБХ
- ✓ ХДК
- ✓ МЭХ
- ✓ Арилжааны банкууд

# Хууль эрх зүйн орчин

- “Монгол улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”
- “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл”
- “Төв банкны тухай хууль”
- “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” тухай хуулийн төсөл
- “Зээлийн хүүг бууруулах стратеги”

# Цаашид хийх ажлууд

1. “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 6.2.1-т “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт санхүүгийн мэдлэг олгох агуулгыг нэвтрүүлэх” зорилт тусгагдсаны дагуу Боловсролын хөтөлбөрт **сонгож** судлахаар тусгагдаад буй **“Бизнес судлал” хичээлийг 10, 11 дүгээр ангид заавал** судлах болгож өөрчлөх;

2. Монголбанкны зүгээс бага, дунд ангийн багш нарыг бэлтгэх, бага, суурь боловсролын түвшний сургалтад ашиглах санхүүгийн боловсролын гарын авлага, зөвлөмжийг гаргах чиглэлээр хамтран ажиллах;

3. **Бичил жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох** дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх

4. Хамтын ажиллагааг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх

# Анхаарал хандуулсанд баярлалаа!

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ www.sankhuugiinbolovsrol.mn

www.mongolbank.mn

@mongolbank_mn

YouTube mongolbank

@mongolbank.mn